

## **“ЭРДЭНЭТ-АВТО ЗАМ” ХК-НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 04 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 01

Баян-өндөр  
сум

Хурал 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт компаний өөрийн байранд болов. Хурал нийт хувьцаа эзэмшигчдийн 91,8%-ийн ирцтэйгээр хуралдав.

Гүйцэтгэх захирал В.Оросмаа ирцийг танилцуулж хурлыг нээв.

- Хурлын тэргүүлэгчдийг сонгож батлав.
- Хурлын даргаар В.Оросмааг сонгож, тэргүүлэгчдээр Д.Дүйнхэржав, Ч.Даваажав, Д.Энхтуяа нарыг сонгов.
- Тооллогын комиссын дарга, гишүүдийг ажиллуулах журмыг танилцуулж батлав.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв.

Үүнд:

1. Компаний 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тэнцлийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах.
3. 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, үндсэн чиглэлийг хэлэлцэж, батлах.
4. УИХ-аас баталсан Аудитын тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан компаний хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлаар дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэв.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцэх асуудлыг санал нэгтэй батлав.

Дараах асуудлыг дарааллын дагуу хэлэлцэв.

**Нэгдүгээр асуудал.** Компаний 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан тэнцлийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гүйцэтгэх захирал В.Оросмаа сонсгол тавив.

### **Асуулт:**

Д.Дүйнхэржав – Компаний 2017 оны жилийн эцсийн тайлан тэнцлийн дүнг сонслоо.Тус компани нь эдийн засгийн хямралтай байдлаас болж зам барилгын ажлын хөрөнгө оруулалтын эх үүсвэр байхгүй байгаагаас 2017 онд төлөвлөгдсөн ажил гүйцэтгэж чадсангүй. Энэ байдлыг цаашид сайжруулахын тулд зам барилгын ажил хийх төсөлд төлөвлөгдсөн ажлуудыг гүйцэтгэж компаний орлого, ашгийг нэмэгдүүлэх тусгай төлөвлөгөө боловсруулж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. 2018 онд төлөвлөгдсөн ажлыг хөрөнгө оруулагчтай хамтран хэрэгжүүлэх талаар хариуцсан комисс томилж, ажиллуулах шаардлагатай.

В.Оросмаа- Зам барилгын ажлыг олж, компаний ашиг орлогыг нэмэгдүүлэх талаар тодорхой ажлыг шинжлэх ухааныг үндэстэй авч үзэх, зам барилгын ажлын чанар, тендерт оролцох тооцоо судалгааг мэрэгжлийн түвшинд хийх.

Ч.Даваажав- 2017 оны жилийн эцсийн тайлан тэнцлээр гарсан орлого, зарлагатай танилцахад цаашид үр дүнтэй ажиллахгүй бол компаний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө. Хувьцаа эзэмшигчид бидний амьдрал ч хүндрэлтэй болж байна. Иймд 2018 онд хийж гүйцэтгэх ажлыг нарийн төлөвлөж, ашиг орлогоо нэмэгдүүлэх тал дээр хатуу анхаарч ажиллах шаардлагатай байна. Аудитын тухай шинэчлэгдсэн хуулийн дагуу компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, компаний хяналтыг сайжруулах талаар гишүүдийн хэлэлцсэн саналыг дүрэмдээ тусгаж шинэчлэн батлах.

Д.Энхтуяа- Компаний үйл ажиллагаанаас бус, Монгол Улсын эдийн засгийн хямрал, зах зээлийн харилцааны нөхцөл байдлаас шалтгаалан зам барилгын ажил хийх нөхцөл боломж байсан ч хөрөнгө мөнгөний хомсдолтой байдлаас болж барилгын ажил төлөвлөсөн хэмжээнд хүрч хийгдээгүй болно. Иймд зам барилгын ажлаас өөрөөр юу хийж болохыг судалж, компанийг тогтмол ажил орлоготой болгох. Үүнд: Зам барилгын туслах үйлдвэрлэлээ дагнаж, өвөл зунгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх.

**Хоёрдугаар асуудал.** ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг үндэслэн 2017 онд хуваарилагдах ногдол ашиггүй байгаа тул энэ саналыг дэмжив.

**Гуравдугаар асуудал.** 2018 онд хийж гүйцэтгэх зам барилгын ажлын төлөвлөгөөг баталж, цаашид зам барилгын ажлын зэрэгцээ өөр салбарт ажиллах боломжуудыг судалж төлөвлөгөө, тооцоо гаргаж ажиллах шаардлагатай дээр инженер техникийн ажилчдаар бусад салбарт сургалт, курс зохион байгуулж, ажиллуулах саналыг зарим байгууллагуудаас ирүүлж байгаа хүлээн авч хэрэгжүүлэх.

#### **ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

1. 2017 оны санхүүгийн тайлан тэнцлийг хэлэлцэж батлав.
2. Ногдол ашиг хуваарилагдахгүй болохыг хэлэлцэж батлав.
3. 2018 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үндсэн чиглэлийг хэлэлцэж батлав.
4. Компаний дүрэмд аудитын шинэчилсэн хуулийн өөрчлөлтийг нэмж оруулан дүрмийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

ТЭРГҮҮЛЭГЧИД

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

В.ОРОСМАА

Д.ЭНХТУЯА

Д.ДҮЙНХЭРЖАВ

Ч.ДАВААЖАВ

Д.ЭНХТУЯА